



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 07 өдөр

Дугаар A/23

Номгон

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.8, 59.1.23, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2023 оны A/27 дугаар захирамж, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.11.1, Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.3.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Баянхонгор сум “Түйн голын жавар-2023” өвлийн наадмыг 2023 оны 02 дугаар сарын 11, 12-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.“Түйн голын жавар-2023” өвлийн наадмыг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, ажлын төлөвлөгөөг хоёрдугаар, шаардагдах зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.“Түйн голын жавар-2023” өвлийн наадмыг зохион байгуулахад шаардагдах 2.500,00 (хоёр сая таван зуун мянга)-н төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга, Төсвийн шууд захирагч (Г.Хүрэлсүх)-д зөвшөөрсүгэй.

4.“Түйн голын жавар-2023” өвлийн наадмыг чанарын өндөр түвшинд зохион байгуулж, үр дүн, ажлын тайланг Засаг даргын зөвлөлд 2023 оны 02 дугаар сарын 18-ны дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (С.Батцэрэн)-д үүрэг болгосугай.

5.“Түйн голын жавар-2023” өвлийн наадмын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, мэдээлэх ажилд хариуцлагатай хандаж ажиллахыг Хэвлэл мэдээлэл, олон нийт ажилтан (Д.Отгонтунгалаг), орон нутгийн телевизийн захирал нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  Г.ЭНХБАЯР





40

Баянхонгор сумын Засаг даргын 2023 оны
...02 дугаар сарын 07 ны өдрийн А/23
дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

С.Батцэрэн

(Засаг даргын Орлогч)

Гишүүд:

(Нийтлэг үйлчилгээний алба)

Н.Пүрэвжаргал

(Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тасгийн

дарга)

Ц.Баасанбат

(Газар зохион байгуулалт, инженерийн шугам

сүлжээ, зам талбай хариуцсан ажилтан)

Д.Уранчимэг

(Нярав)

Ж.Дэлгэрмаа

(Байгаль орчны асуудал хариуцсан

мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Б.Ууганзаяа


(Худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээ хариуцсан

Мэргэжилтэн)

_____оОо_____

41

Баянхонгор сумын Засаг даргын 2023 оны
 02 дугаар сарын 07-ны өдрийн 123
 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



ТҮЙН ГОЛЫН ЖАВАР-2023 ӨВЛИЙН НААДАМ
 ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1	2	3	4
1	Хээрийн цайны амт шалгаруулахад бэлтгэх	2023 оны 02 дугаар сарын 11,12	Г.Должинсүрэн Г.Бадамханд
2	Байгууллагын гэрийг зурагт заасан газарт барих	2023 оны 02 дугаар сарын 8-10	Ж.Хүрэлбаатар Н.Чулуунбаатар Д.Ариунболд Д.Отгонбаатар Х.Баянмөнх
3	Гэр тохижуулах	2023 оны 02 дугаар сарын 8-10	Ажлын хэсэг, Б.Ууганзаяа
4	Эрчим хүчээр хангах	2023 оны 02 дугаар сарын 11,12	Ц.Нармандах
5	Мөсөн бүтээл хийх	2023 оны 02 дугаар сарын 8-10	Ж.Хүрэлбаатар Н.Чулуунбаатар Д.Ариунболд Д.Отгонбаатар Х.Баянмөнх
6	Сайхан хос шалгаруулах тэмцээнд оролцох	2023 оны 02 дугаар сарын 11,12	Ц.Баярмагнай А.Батаа
7	Мөсөн шагай тэмцээнд оролцуулах	2023 оны 02 дугаар сарын 11,12	Г.Хүрэлсүх Ц.Баасанбат Ц.Нармандах У.Баяржаргал Г.Бадамханд О.Цэндмаа
8	Байгууллагын хаягийг гэрийн гадна талд байршуулах	2023 оны 02 дугаар сарын 11,12	Д.Уранчимэг
9	Наадмын зохион байгуулалтыг схем зураг үйлдэж иргэн аж ахуйн нэгж байгууллагуудад мэдээллэх гэр барих байршлыг тэмдэгжүүлэх хяналт тавих	2023 оны 02 дугаар сарын 8-10	Ажлын хэсэг
10	Тэшүүрийн тэмцээнд оролцох	2023 оны 02 дугаар сарын 11,12	О.Дашдаваа Б.Гантөмөр Ө.Цэвээнбат Б.Баасанжаргал Э.Балжинням Л.Цолмонжаргал
11	Өвлийн баяр наадам болох газарт цэвэрлэгээ хийх	2023 оны 02 дугаар сарын 5-10	Байгаль орчны алба

42

Баянхонгор сумын Засаг даргын 2023 оны
...02... дугаар сарын ...07... ны өдрийн А/23...
дугаар захирамжийн ...3... дугаар хавсралт

ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Нэрс	Ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	2	3	4	5
1	Ууцны мах	1 ш	350000	350000
2	Шингэн сүү	5 л	8000	40000
3	Шар тос	5 кг	35000	175000
4	Цайны идээ	1 ш	15000	15000
5	Хуушуур мах	15 кг	13000	195000
6	Гурил	15 кг	3500	52500
7	Тавгийн чихэр	5 кг	20000	100000
8	Шар будаа	1 кг	6500	6500
9	Тавгийн боов	50 ш	5500	275000
10	Тавгийн ааруул	5 кг	25000	125000
11	Ингэний ундаа	40 л	13000	520000
12	Аарц	10 кг	8000	80000
13	Цайны хийц	8 ш	5300	42400
14	Өрөм	3 кг	25000	75000
15	1 удаа аяга	10 боодол	4500	45000
16	1 удаа тавга	10 боодол	6500	65000
17	1 удаа халбага	2 боодол	2500	5000
18	Сахар	5 кг	4000	20000
19	Сальфетик (хуурай)	3 ш	4000	12000
20	Салвфетик (нойтон)	2 ш	5500	11000
21	Сонгино	4 кг	3000	12000
22	Мод	5 ш	7000	35000
23	Аргал	10 ш	6500	65000
24	Нүүрс	12 ш	3500	42000
25	Шатахууны зардал (гэр зөөх болон хог цэвэрлэх)			136600
	ДҮН			2,500,000